



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 122

Улаанбаатар хот

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд
өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 6.12 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эм Ай Си Си ҮЦК” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 417,591,259.44 /дөрвөн зуун арван долоон сая таван зуун ерэн нэгэн мянга хоёр зуун тавин есөн төгрөг дөчин дөрвөн мөнгө/ төгрөгөөр нэмэгдүүлж, хавсралтад заасны дагуу хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “Эм Ай Си Си ҮЦК” ХХК /Д.Ачит-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.


3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц /-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны
2020 оны 03 дүгээр сарын 25-ны өдрийн
122 дугаар тогтоолын хавсралт



“Эм Ай Си Си ҮЦК” ХХК-ийн хувь нийлүүлсэн
хөрөнгийн хэмжээнд оруулах өөрчлөлт

№	Хувьцаа эзэмшигчийн нэр, /Регистрийн дугаар/	Хувьцааны нэрлэсэн үнэ/₮/	Хувьцааны эхний үлдэгдэл			Өөрчлөлт		Хувьцааны эцсийн үлдэгдэл		
			Тоо ширхэг	Үнийн дүн/₮/	Эзлэх хувь %/	Хувьцааны тоо	Үнийн дүн/₮/	Тоо ширхэг	Үнийн дүн/₮/	Эзлэх хувь %/
1	Дарамбазар овогтой Ачит- Эрдэнэ /РД:ХЖ76081077/	1,075.936₮	456,537	491,204,658.4	50.0%	194,059	208,795,091.75	650,596	699,999,750.15	50.0%
2	Жийл Гурьер Де Думаст /Паспорт дугаар: 16FV03519/	1,075.936₮	227,356	244,620,537.5	24.9%	96,642	103,980,620.62	323,998	348,601,158.09	24.9%
3	Долгион- Инженеринг ХХК /РД:5660629/	1,075.936₮	229,181	246,584,120.9	25.1%	97,418	104,815,547.07	326,599	351,399,668.00	25.1%
Нийт			913,074	982,409,316.8	100%	388,119	417,591,259.44	1,301,193	1,400,000,576.24	100%